

2008.01.31

Дугаар12

Хадгаламж, зээлийн зарим хоршоодод  
тусгай зөвшөөрөл олгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.3, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10.1.1, 15.3.4, Хоршооны тухай хуулийн 48<sup>1</sup>.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагыг хангасан хавсралтад дурдсан нэр бүхий 11 хоршоонд 2008 оны 01 дүгээр сарын 31-ний өдрөөс эхлэн хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 3 жилийн хугацаагаар олгосугай.

2. Санхүүгийн болон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийн тайланг улирал бүр гаргаж, зохих журмын дагуу тогтоосон хугацаанд Хороонд ирүүлж, холбогдох хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлж ажиллахыг тусгай зөвшөөрөл авсан хадгаламж, зээлийн хоршоодын удирдлагад үүрэг болгосугай.

3. Тусгай зөвшөөрөл авсан хадгаламж, зээлийн хоршоодын үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж ажиллахыг Хадгаламж, зээлийн хоршоодын газар /Б.Мөнхжаргал/-т даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

Хуулбар үнэн:  
АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА

О.ГАНБАТ

*Монгол улсын Санхүүгийн зохицуулах  
хорооны 2008 оны 12 дугаар  
тогтоолын хавсралт*

<i>№</i>	<i>ХЗХ-ны нэр</i>	<i>Хориооны дарга</i>	<i>Байриил</i>	<i>Хянасан байцаагчийн нэр</i>
1	“Финстар”	Ц.Оюунжаргал	Чингэлтэй дүүрэг, 6-р хороо Таван богд плаза 1-р давхарт	К.Булбул
2	“Кварц”	А.Ганлхагва	Сүхбаатар дүүрэг, 8-р хороо Бага тойруу, Эм Ди Эл ХХК- ний байр 10 тоот	К.Булбул
3	“Арвижих билэг”	Б.Дашням	Дорноговь аймаг сайншанд 2-р баг намын хорооны 103 тоотод утас 22334	П.Наранцэцэг
4	“Элпи”	Д.Лхамсүрэн	Сүхбаатар дүүрэг, 6-р хороо, Бага тойруу, 40.207	Н.Энхтуяа
5	“Шинэ зэс”	Б.Халтар	Орхон аймгийн Баян-Өндөр сум Чандмана төвийн байранд	Б.Пүрэв
6	“Техник шинэчлэл”	Б.Гантулга	Улаанбаатар хот Баянзүрх дүүрэг 4-р хороо Доржийн гудамж 4/48 тоот	Б.Солонго
7	“Дэлүүн бүргэд Хайрхан”	М.Бригад	Баян-Өлгий аймаг, Дэлүүн сум 9-р баг	С.Тулгаа
8	“Идэрийн ундрага”	Ш.Болор-Эрдэнэ	Завхан аймгийн Улиастай сум, Жинст баг Аймгийн ЗДТГ-ын байранд	Л.Энхбаяр
9	“Хамтын хөгжлийн чуулган”	Ч.Батзориг	Сүхбаатар дүүрэг, 6-р хороо, Бага тойруу, НҮБ-ийн гудамж, 27-02 тоот	Б.Батмаа
10	“Арсондор”	Г.Дашцэрэн	Архангай аймаг, Төвшрүүлэх сум, 4-р баг, Засаг даргын тамгын газрын байр	Б.Батмаа
11	“Батбаяр ар”	Л.Аварзэд	Архангай аймаг, Эрдэнэбулган сум, ХОСТ байранд	Б.Батмаа